



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/197

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багш нарын баярыг тохиолдуулан шилдэг багш, ажилчдыг шагнах шагналын зардал, ойн салбарын 100 жилийн ойд зориулсан арга хэмжээний шагналын зардал, ахмадын баярыг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх зардалд 575,000 (таван зуун далан таван мянга) төгрөг, шагналын өргөмжлөл, медалийн зардалд 570,000 (таван зуун далан мянга) төгрөг, нийт 1,145,000 (нэг сая нэг зуун дөчин таван мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах 1,145,000 (нэг сая нэг зуун дөчин таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН